



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/318

Чингис хот

“Нөхөн сэргээлт-2020” арга хэмжээг
зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын “н”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.2.1, 16.2.4, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 39 дүгээр зүйлийн 39.3, 39.7, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам батлах тухай” 151 дүгээр, 2019 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 355 дүгээр, 2020 оны “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоолууд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын баталсан “Нөхөн сэргээлт-2020” ерөнхий арга хэмжээ зохион явуулах төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | | |
|-----------------------|---------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Сүнгээ | Мэргэжлийн хяналтын газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | Б.Дархантөр | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |
| Гишүүд: | Э.Мөнх-Эрдэнэ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| | Ц.Баярхүү | Аймгийн Цагдаагийн газрын дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн дэд хурандаа |

| | |
|--------------|--|
| Б.Энхбат | 2. Экологийн ажил хариуцсан эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад |
| Т.Лхагвадорж | Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч |

2. "Нөхөн сэргээлт-2020" ерөнхий арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөөний хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын дэд төлөвлөгөөг боловсруулан, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, мэдээ тайланг хугацаанд нь багтаан хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Сүнгээ/-д даалгасугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах хөрөнгө санхүүг холбогдох агентлаг, байгууллагууд өөрсдийн зардлаар хариуцахыг чиглэл болгож, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА